



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хөшөө цайдам музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/25/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор Л.Соёлмөнх Утас: 703333019 Цахим хаяг: soyolmunkhl@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.15 № 11
танай _____ -ны № _____ -т

ХӨШӨӨ ЦАЙДАМ МУЗЕЙН
ДАРГА Т.НАРАНГЭРЭЛ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хөшөө цайдам музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Хөшөө цайдам музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,113,133.83	6,807,250.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	21,587.00	21,587.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	21,587.00	21,587.00
31140	Касс арилжааны банк	21,587.00	21,587.00
33	АВЛАГА	121,983.83	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	121,983.83	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,969,563.00	6,785,663.00
35400	Хангамжийн материал	6,969,563.00	6,785,663.00
35410	Бичиг хэргийн материал	604,900.00	682,520.00
35420	Аж ахуйн материал	6,364,663.00	6,103,143.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	290,178,437.57	290,187,685.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	290,178,437.57	290,187,685.15
39200	Биет хөрөнгө	270,178,437.57	270,187,685.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	139,875,599.00	139,875,599.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,993,780.00	-10,490,670.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,000,000.00	21,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,000,000.00	-21,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	26,178,602.75	31,141,802.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	-26,178,602.75	-26,840,362.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,807,324.00	24,807,324.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,260,705.43	-23,056,007.83
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	134,750,000.00	134,750,000.00
39300	Биет бус хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	297,291,571.40	296,994,935.15
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	297,291,571.40	296,994,935.15
51	Засгийн газрын хувь оролцоо	297,291,571.40	296,994,935.15
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	71,985,600.00	71,985,600.00
51200	Хуримтлагдсан үр дүн	225,305,971.40	225,009,335.15
51210	Өмнөх үеийн үр дүн	232,356,252.81	225,305,971.40
51220	Тайлант үеийн үр дүн	-7,050,281.41	-296,636.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	297,291,571.40	296,994,935.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	195,727,700.00	191,770,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	4,963,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	4,963,200.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	4,963,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	195,727,700.00	186,807,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	195,127,700.00	185,167,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	195,127,700.00	185,167,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	600,000.00	1,640,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	600,000.00	1,640,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	202,777,981.41	192,066,836.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	202,777,981.41	192,066,836.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	194,461,601.41	190,760,490.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,738,384.00	146,764,314.00
210101	Үндсэн цалин	104,823,169.00	105,140,854.00
210102	Нэмэгдэл	41,110,554.00	41,093,800.00
210104	Урамшуулал	804,661.00	529,660.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,455,752.17	19,047,923.83
210201	Тэтгэврийн даатгал	12,639,956.17	13,182,906.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,453,711.00	1,466,252.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,223,485.00	1,173,002.55
210204	Ажилгүйдлийн даатгал	228,495.00	293,252.95
210205	Эрүүл мэндийн даатгал	2,910,105.00	2,932,509.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,607,000.00	9,386,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,737,000.00	2,086,000.00
210302	Түлш, халаалт	8,270,000.00	6,820,000.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	480,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,558,140.00	5,440,020.00
210401	Бичиг хэрэг	304,800.00	427,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,489,400.00	2,546,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	444,700.00	376,800.00
210404	Ном, хэвлэл	195,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,000.00	18,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,106,240.00	2,070,820.00
2105	Нормативт зардал	761,400.00	685,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	761,400.00	685,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,164,000.00	1,719,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,164,000.00	1,039,200.00
210604	Урсгал засвар	0.00	680,000.00
2107	Томилолт, зочны зардал	132,000.00	96,000.00
210702	Дотоод албан томилолт	132,000.00	96,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,047,980.00	2,667,980.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,390,700.00	1,950,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	45,000.00	36,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,500.00	47,500.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165,000.00	165,000.00
210807	Газрын төлбөр	60,000.00	70,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	156,780.00	166,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,996,945.24	4,953,952.42
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,996,945.24	4,953,952.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,316,380.00	1,306,346.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,914,660.00	327,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,504,660.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	327,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,401,720.00	979,346.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,401,720.00	979,346.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-7,050,281.41	-296,636.25
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-7,050,281.41	-296,636.25

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	71,985,600.00	0.00	232,356,252.81	304,341,852.81
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,985,600.00	0.00	232,356,252.81	304,341,852.81
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-7,050,281.41	-7,050,281.41
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,985,600.00	0.00	225,305,971.40	297,291,571.40
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	71,985,600.00	0.00	225,305,971.40	297,291,571.40
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,985,600.00	0.00	225,305,971.40	297,291,571.40
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-296,636.25	-296,636.25
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	71,985,600.00	0.00	225,009,335.15	296,994,935.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	195,785,287.00	186,807,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,587.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	57,587.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57,587.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,587.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	195,727,700.00	186,807,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	195,127,700.00	185,167,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	195,127,700.00	185,167,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	600,000.00	1,640,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	600,000.00	1,640,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	195,763,700.00	186,807,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	195,763,700.00	186,807,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	187,447,320.00	185,500,654.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,774,384.00	146,764,314.00
210101	Үндсэн цалин	104,823,169.00	105,140,854.00
210102	Нэмэгдэл	41,110,554.00	41,093,800.00
210104	Урамшуулал	840,661.00	529,660.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,577,736.00	18,925,940.00
210201	Тэтгэврийн даатгал	12,722,905.00	13,109,934.08
210202	Тэтгэмжийн даатгал	1,463,470.00	1,448,013.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,231,292.00	1,160,840.42
210204	Ажилгүйдлийн даатгал	230,447.00	292,037.06
210205	Эрүүл мэндийн даатгал	2,929,622.00	2,915,114.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,607,000.00	9,386,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,737,000.00	2,086,000.00
210302	Түлш, халаалт	8,270,000.00	6,820,000.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	480,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,184,300.00	5,216,900.00
210401	Бичиг хэрэг	289,800.00	439,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,489,400.00	2,546,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	444,700.00	376,800.00
210404	Ном, хэвлэл	108,000.00	86,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,000.00	18,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,834,400.00	1,749,300.00
2105	Нормативт зардал	761,400.00	685,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	761,400.00	685,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,374,000.00	1,779,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,374,000.00	1,099,200.00
210604	Урсгал засвар	0.00	680,000.00
2107	Томилолт, зочны зардал	132,000.00	96,000.00
210702	Дотоод албан томилолт	132,000.00	96,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,036,500.00	2,647,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,390,700.00	1,950,400.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	45,000.00	36,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,500.00	47,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165,000.00	165,000.00
210807	Газрын төлбөр	60,000.00	70,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	145,300.00	145,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,316,380.00	1,306,346.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,914,660.00	327,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,504,660.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	327,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,401,720.00	979,346.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,401,720.00	979,346.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	21,587.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	21,587.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	21,587.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,587.00	21,587.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	185,167,000.00	184,187,654.00	979,346.00	99.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	185,167,000.00	184,187,654.00	979,346.00	99.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	184,839,000.00	183,860,654.00	978,346.00	99.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,834,000.00	146,764,314.00	69,686.00	99.95
210101	Үндсэн цалин	104,861,800.00	105,140,854.00	279,054.00	100.27
210102	Нэмэгдэл	41,093,800.00	41,093,800.00	0.00	100.00
210104	Урамшуулал	878,400.00	529,660.00	348,740.00	60.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,822,600.00	18,925,940.00	896,660.00	95.48
210201	Тэтгэврийн даатгал	13,949,200.00	13,109,934.08	839,265.92	93.98
210202	Тэтгэмжийн даатгал	1,468,300.00	1,448,013.48	20,286.52	98.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,174,700.00	1,160,840.42	13,859.58	98.82
210204	Ажилгүйдлийн даатгал	293,700.00	292,037.06	1,662.94	99.43
210205	Эрүүл мэндийн даатгал	2,936,700.00	2,915,114.96	21,585.04	99.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,386,000.00	9,386,000.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,086,000.00	2,086,000.00	0.00	100.00
210302	Түлш, халаалт	6,820,000.00	6,820,000.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	480,000.00	480,000.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,324,100.00	4,324,100.00	0.00	100.00

Архангай аймгийн Хөшөө цайдам музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	239,800.00	239,800.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	2,546,600.00	2,546,600.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	376,800.00	376,800.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	86,400.00	86,400.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,800.00	14,800.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,059,700.00	1,059,700.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	685,100.00	685,100.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	685,100.00	685,100.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,099,200.00	1,099,200.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,099,200.00	1,099,200.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	100,300.00	96,000.00	4,300.00	95.71
210702	Дотоод албан томилолт	100,300.00	96,000.00	4,300.00	95.71
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,587,700.00	2,580,000.00	7,700.00	99.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,950,400.00	1,950,400.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	36,000.00	36,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,200.00	47,500.00	7,700.00	86.05
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,400.00	29,400.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	132,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	39,400.00	39,400.00	0.00	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	145,300.00	145,300.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	328,000.00	327,000.00	1,000.00	99.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	328,000.00	327,000.00	1,000.00	99.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	327,000.00	1,000.00	99.70
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	185,167,000.00	184,187,654.00	979,346.00	99.47
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	185,167,000.00	184,187,654.00	979,346.00	99.47
310001	Улсын төсвөөс санхүүжих	185,167,000.00	184,187,654.00	979,346.00	99.47
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	21,587.00	-21,587.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	21,587.00	-21,587.00	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	29	29	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	14	14	0.00	100.00

620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	4	4	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,640,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,640,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,640,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	892,800.00
210401	Бичиг хэрэ	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	689,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	680,000.00
210604	Урсгал засвар	680,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,600.00
210806	Мэдээллийн технологийн зардал	33,000.00
210807	Газрын төлбөр	30,600.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,640,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,640,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,640,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Хөшөө цайдам музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Соёлмөнх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөшөө цайдам музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17 - ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Хөшөө цайдам музей нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр төр улсаа байгуулж байсан Түрэг угсааны түүхтэй холбогдох Билгэ хаан, Культегин жанжин нарын онгон, тахилгын дурсгалыг хадгалж хамгаалах, судлаж, сурталчилгааны эх үүсвэр болгон ашиглах, түүх соёлтой холбогдох бодит эд зүйлс, олдворт тулгуурласан мэдээллийг нийтийн хүртээл болгоно. Дэлхийн-Өв Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын нутаг дэвсгэр дээр орших учраас Улаанбаатар-Хархорин-Хөшөө цайдам-Өгийнуур гэсэн соёлын аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох зорилготой соёл урлагын үйл ажиллагаа явуулдаг, улсын төсөв болон өөрийн орлогоор санхүүждэг, Соёлын яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд дараах зорилтуудыг тавин ажилласан байна. Үүнд:

- Хууль тогтоомж, эрх зүйн актаар тогтоогдсон үндсэн үүрэг хариуцлагыг хүлээж, эрхээ эдлэх,
- Музейн үйл ажиллагаанд шинийг нэвтрүүлэх,
- Музейн орлогыг тогтмол ахиулах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх,
- Музейн хүний нөөцийн чадавхийг чанаржуулах,
- Музейн мэдээллийн нэгдсэн сан байгуулж олон нийтэд сурталчлах, электрон хэлбэрээр хүргэх,
- Үзэгчдэд түргэн шуурхай чанартай үйлчилж, музейг уртасгасан цагаар ажиллах нөхцлийг хангах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Соёлын тухай хуульд 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр өөрчлөлт орсон байна. Харин санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.7" гэснийг "11.7" гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсүгэй” гэснээр даатгуулагч болон ажил олгогчоос төлөх НДШ тус бүр 1%-аар буурч өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагаанд дотоод хяналтын нэгжээс 2021 онд 10 чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулахаар төлөвлөж, төлөвлөгөөний дагуу өмчийн бүртгэл тооцоо, хөрөнгийн ашиглалт хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, үүрэг даалгавар өгч ажилласан байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын дарга Ц.Нацагдолгороор ахлуулсан ажлын хэсэг 2021 оны 3 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд музейн ажил байдалтай танилцаж, сан хөмрөг бүртгэлийн албаны ажил болон бүртгэл мэдээллийн хөтлөлт бүрэн зөв хөтөлж байгаа эсэхэд хяналт тавьж, ажил сайжруулах чиглэлээр үнэлэлт дүгнэлт өгч ажилласан байна. Соёлын яамны Хяналт шалгалт үнэлгээний газар нь улирал тутамд шилэн дансны хэрэжилтэд хяналт тавьж заавар зөвлөмж өгч ажилладаг байна.

Хөшөө цайдам музей нь Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2021 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт 2021 онд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд бусад эрх бүхий байгууллагаас болон хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Хөшөө цайдам музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 185.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 1.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 0.3 сая төгрөгөөр буюу 0.1 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материалын данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Мөнгө ба түүний адилтгах хөрөнгө	0.02	0.02	0.0	0.0
Авлага	0.1	0.0	-0.1	-100.0
Бараа материал	6.9	6.7	-0.2	-2.9
Үндсэн хөрөнгө	290.1	290.2	0.1	0.03
Нийт хөрөнгө	297.2	296.9	-0.3	-0.1

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	297.2	296.9	-0.3	-0.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	297.2	296.9	-0.3	-0.1

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 2.9 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 6.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 15.1 төгрөг нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 15.3 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 6.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 0.03 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 367.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд Соёлын яамнаас үнэ төлбөргүй хүлээн авсан 4.9 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжөөр нэмэгдэж, актлаж данснаас хассан хөрөнгө байхгүй, тайлант хугацаанд байгуулсан 82.1 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, 290.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Өр төлбөр данс нь тайлант хугацаанд өргүй ажилласан байна.
- Авлагын үлдэгдэл өмнө оноос 100 хувиар буурсан байна.

Авлагын данс нь тайлант хугацаанд 0.1 сая төгрөгийн авлагаа төвлөрүүлж, жилийн эцсээр авлагын үлдэгдэлгүй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүн 0.3 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	195.12	186.80	-8.32
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.60	1.64	1.04
Татварын бус орлого	0.00	4.96	4.96
Үйл ажиллагааны орлого	195.72	193.41	-2.31
Цалин, шимтгэлийн зардал	165.19	165.81	0.61
Бусад бараа үйлчилгээний зардал	27.53	18.63	-8.90
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3.04	2.66	-0.38
Бараа үйлчилгээний бусад зардал	6.99	4.95	-2.04
Үйл ажиллагааны зардал	202.77	192.06	-10.71
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-7.05	1.34	8.39
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	0.00	0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-7.05	1.34	8.39

Хөшөө цайдам музейн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 2.5 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт буурсантай холбоотой бөгөөд 2021 онд батлагдсан зардлыг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 203.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 18.1 сая төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 185.1 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 185.1 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 185.1 сая төгрөгийн орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 184.2 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан, 0.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 0.9 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.6 сая төгрөг төвлөрсөнг хангамж, бараа материалын зардалд 0.9 сая төгрөгийг, урсгал зардалд 0.6 сая төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 0.06 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хөшөө цайдам музей нь 2021 онд шинээр батлагдсан Ковид-19 цар тахлын үед улс, аймаг сумын онцгой комиссоос аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгааны дагуу соёл урлагийн үйлчилгээг хориглосны улмаас соёл урлагийн болон олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 185.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 184.2 сая төгрөгийг зарцуулж, 0.9 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

- Өндөр насны тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн албан тушаалтан байхгүй.

- Урсгал зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

2. Суудлын автомашин ашиглалтын хувьд: АРА29-92 дугаартай УАЗ Пургон маркийн 2011 онд үйлдвэрлэсэн 21.0 сая төгрөгийн анхны өртөг бүхий автомашинтай бөгөөд шатахууны зардалд 2.5 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочгүй.

Тайлант онд төсвийн тодотголоор нийт зардал 2.9 сая төгрөгөөр буурч, зардлын хэмнэлтээр 0.9 сая төгрөг нийт 3.8 сая төгрөг буюу 1.5 хувийн хэмнэлтийг бий болгосон байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэл байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль, Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоолын хэрэгжилтийг шалгалаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөшөө цайдам музей нь 2021 онд 3 мэдээллийг хугацаа хоцроосон бөгөөд нийт 185.2 сая төгрөгийн 12 орлогын, 6.8 сая төгрөгийн 6 зарлагын гүйлгээг Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулахаас 6.8 сая төгрөгийн 6 зарлагын гүйлгээний мэдээллийг ил тод мэдээллээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ ...”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг мэдээллэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд батлагдсан төсвөөс 2.9 сая төгрөгийг төвлөрүүлэн 13.6 хувийн хэмнэлтийг бий болгосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн тувшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг анхан шатны баримтад үндэслэн нарийвчлан шалгана.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.9 сая төгрөгийн алдааг залруулж, 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар хандиваар өгсөн 4.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогоор тусгуулан залруулга хийлгэлээ.

4.2 Төлбөрийн акт

Албан томилолтын зардлыг 290.0 мянган төгрөгийг илүү олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалыг зөрчин 406.0 мянган төгрөгийн томилолтыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас судалгаа шинжилгээний ажлаар явахад зарцуулсан зөрчил илэрлээ.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", 2018 оны 6 дугаар сарын 8-ний өдрийн 134 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх, зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй ажиллах, Албан шаардлага өгөх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

- **Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Тээвэр шатахууны зарцуулалтын 2672.6 мянган төгрөгийн жолоочийн тооцооны хуудсыг буруу хөтөлсөн, шаардах хуудас бичээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 6.4 дэх заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Сангийн сайдын 347 дугаар тушаалыг мөрдөн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг хангуулж ажиллах зөвлөмжийг өгч байна.

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хөшөө цайдам музей	4	5.6	1	4.9	1	0.3	1	0.4	1	0
Дүн		4	5.6	1	4.9	1	0.3	1	0.4	1	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хөшөө цайдам музей	1	0	0	0	0	0	0	0	1	0
Дүн		1	0	0	0	0	0	0	0	1	0
Нийт дүн		5	5.6	1	4.9	1	0.3	1	0.4	2	0